



НИЙСЛЭЛИЙН
СТАТИСТИКИЙН
ГАЗАР



Хөдөө аж ахуйн салбар 2024

Улаанбаатар хот
2025 он

ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭН БОЛОВСРУУЛСАН:

З.Халиун

Нийслэлийн статистикийн газрын
Эдийн засгийн статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

ТАНИЛЦУУЛГЫГ ХЯНАСАН:

Х.Отгонзул

Нийслэлийн Статистикийн газрын дарга

Ө.Нямжаргал

Нийслэлийн Статистикийн газрын
Эдийн засгийн статистикийн хэлтсийн дарга

НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР

Монгол Улс, Улаанбаатар хот

Нийслэлийн нутгийн захиргааны Б блок

Утас: (976-51)-261223, (976-51)-261224

Факс:

Цахим хуудас: www.ubstat.mn

Имэйл: ulanbaatar@nso.mn



ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА 2024 ОН

АГУУЛГА

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	5
ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	6
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	7
НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ	8
БҮЛЭГ 1. МАЛ АЖ АХУЙ	12
I НИЙТ МАЛЫН ТОО	13
1.1 Өрхийн болон аж ахуйн нэгж, байгууллагын малын тоо	15
1.2 Малтай өрхийн малын бүлэглэлт	16
1.3 Малчин өрхийн малын бүлэглэлт	17
II МАЛТАЙ БОЛОН МАЛЧИН ӨРХ, ТЭДГЭЭРИЙН СОЁЛ, АХУЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	18
2.1 Малтай өрх, малчин өрхийн тоо, байршил	18
2.2 Малчин өрхийн ам бүл	21
2.3 Малчин өрхийн зарим үзүүлэлт	21
III МАЛЧДЫН МЭДЭЭЛЭЛ	22
3.1 Малчдын тоо	22
3.2 Малчдын нас, хүйс	23
3.3 Үндсэн болон туслах малчин	24
3.4 Малчдын боловсролын мэдээлэл	24
3.5 Малчдын гэрлэлтийн байдал	27
3.6 Малчдын гар утас болон интернэтийн хэрэглээ	28
3.7 Зээлтэй малчид	30
IV СҮРГИЙН БҮТЭЦ	31
V ХЭЭЛТЭГЧ МАЛ	33
VI ТӨЛ БОЙЖИЛТ	35
VII ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ	38
VIII ТЭЖЭЭВЭР АМЬТАД	40
БҮЛЭГ 2. ГАЗАР ТАРИАЛАН	41
IX ГАЗАР ТАРИАЛАН	42
БҮЛЭГ 3. ХАВСРАЛТ ХҮСНЭГТ	45

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

- ХҮСНЭГТ 1. НИЙСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД ТООЛОГДСОН МАЛЫН ТОО, оноор, төрлөөр
ХҮСНЭГТ 2. МАЛЫН ТОО, дүүргээр
ХҮСНЭГТ 3. МАЛЫН ТОО, төрлөөр, дүүргээр
ХҮСНЭГТ 4. ӨРХИЙН АЖ АХУЙН БУЮУ ХУВИЙН МАЛЫН ТОО, малын төрлөөр
ХҮСНЭГТ 5. ӨРХИЙН АЖ АХУЙН БУЮУ ХУВИЙН МАЛЫН ТОО, дүүргээр
ХҮСНЭГТ 6. АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН МАЛЫН ТОО, малын төрлөөр
ХҮСНЭГТ 7. МАЛТАЙ ӨРХИЙН МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ, өрхийн тоогоор
ХҮСНЭГТ 8. МАЛТАЙ ӨРХИЙН МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ, оноор, малын төрлөөр
ХҮСНЭГТ 9. МАЛЧИН ӨРХИЙН МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ, малын төрлөөр
ХҮСНЭГТ 10. МАЛЧИН ӨРХИЙН МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ, өрхийн тоогоор
ХҮСНЭГТ 11. МАЛТАЙ ӨРХИЙН ТОО, дүүргээр
ХҮСНЭГТ 12. МАЛЧИН ӨРХИЙН ТОО, дүүргээр
ХҮСНЭГТ 13. МАЛ БҮХИЙ ӨРХИЙН ТОО, дүүргээр
ХҮСНЭГТ 14. МАЛТАЙ БОЛОН МАЛЧИН ӨРХ, дүүрэг, хороогоор
ХҮСНЭГТ 15. МАЛЧИН ӨРХ, МАЛЧИН ӨРХИЙН АМ БҮЛ, НЭГ ӨРХӨД НОГДОХ МАЛЫН ТОО, 2024 ОН, малын тооны бүлэглэлтээр
ХҮСНЭГТ 16. МАЛЧИН ӨРХИЙН СОЁЛ АХУЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД
ХҮСНЭГТ 17. МАЛЧДЫН ТОО, дүүргээр
ХҮСНЭГТ 18. МАЛЧДЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, насны бүлгээр, 2024 онд
ХҮСНЭГТ 19. БАГА БОЛОВСРОЛТОЙ МАЛЧИД, хүйсээр, 2024 онд
ХҮСНЭГТ 20. ДЭЭД БОЛОВСРОЛТОЙ МАЛЧИД, хүйсээр, 2024 онд
ХҮСНЭГТ 21. МАЛЧДЫН ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, насны бүлэг, гэрлэлтийн байдлаар, 2024 онд
ХҮСНЭГТ 22. МАЛЧДЫН ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, хувиар, дүүргээр, 2024 онд
ХҮСНЭГТ 23. МАЛЧДЫН ГАР УТАС БОЛОН ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭЭ, насны бүлгээр
ХҮСНЭГТ 24. МАЛЧДЫН ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, дүүргээр
ХҮСНЭГТ 25. МАЛЧДЫН ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭ, дүүргээр
ХҮСНЭГТ 26. ЗЭЭЛТЭЙ МАЛЧИД, насны бүлгээр
ХҮСНЭГТ 27. ЗЭЭЛТЭЙ МАЛЧИД, дүүргээр
ХҮСНЭГТ 28. СҮРГИЙН БҮТЭЦ, 2024 ОН, малын төрлөөр
ХҮСНЭГТ 29. ТӨЛЛӨСӨН ХЭЭЛТЭГЧ, оноор
ХҮСНЭГТ 30. ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО, дүүргээр
ХҮСНЭГТ 31. ТӨЛЛӨСӨН ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО, дүүргээр
ХҮСНЭГТ 32. БОЙЖУУЛСАН ТӨЛ, төрлөөр
ХҮСНЭГТ 33. ТӨЛ БОЙЖИЛТ, малын төрлөөр
ХҮСНЭГТ 34. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, малын төрлөөр
ХҮСНЭГТ 35. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, дүүргээр
ХҮСНЭГТ 36. ТЭЖЭЭВЭР АМЬТАД, амьтдын төрлөөр
ХҮСНЭГТ 37. ТЭЖЭЭВЭР АМЬТАД, дүүргээр, 2024 онд
ХҮСНЭГТ 38. ТАРИАЛАН ЭРХЭЛСЭН ӨРХ, АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА, дүүргээр
ХҮСНЭГТ 39. ТАРИАЛСАН ТАЛБАЙ, төрлөөр
ХҮСНЭГТ 40. ХУРААСАН УРГАЦ, ургамлын төрлөөр, 2024 онд

ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

- ЗУРАГ 1. МАЛЫН ТОО, улсын дүнтэй харьцуулснаар, оноор
- ЗУРАГ 2. САРЛАГИЙН ТОО, оноор
- ЗУРАГ 3. НИЙТ ӨРХӨД МАЛЧИН ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, оноор
- ЗУРАГ 4. МАЛ БҮХИЙ ӨРХИЙН ТОО, дүүргээр
- ЗУРАГ 5. НИЙТ МАЛТАЙ ӨРХӨД, ТАВИУЛ МАЛТАЙ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, оноор
- ЗУРАГ 6. МАЛЧДЫН ТОО, 2024 он, дүүргээр
- ЗУРАГ 7. МАЛЧДЫН НАСНЫ БҮТЭЦ, хувиар
- ЗУРАГ 8. МАЛЧДЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, нийт малчдын дүнд эзлэх хувиар
- ЗУРАГ 9. ҮНДСЭН БОЛОН ТУСЛАХ МАЛЧНЫ ХАРЬЦАА, насны бүлгээр, эзлэх хувиар, 2024 онд
- ЗУРАГ 10. ҮНДСЭН БОЛОН ТУСЛАХ МАЛЧИД, дүүргээр
- ЗУРАГ 11. МАЛЧДЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, 2024 он, хүйсээр
- ЗУРАГ 12. БОЛОВСРОЛГҮЙ МАЛЧИД, насны бүлгээр, хувиар
- ЗУРАГ 13. ДҮҮРГИЙН МАЛЧДЫН ТООНД БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛТОЙ МАЛЧДЫН ЭЗЛЭХ ХУВЬ, дүүргээр, 2024 онд
- ЗУРАГ 14. СУУРЬ БОЛОН ТЕХНИКИЙН, ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ДУНД БОЛОВСРОЛТОЙ МАЛЧДЫН ЭЗЛЭХ ХУВЬ, дүүргээр, 2024 онд
- ЗУРАГ 15. МАЛЧДЫН ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, насны бүлгээр, 2024 онд
- ЗУРАГ 16. НИЙТ МАЛЧДАД ГАР УТАСТАЙ МАЛЧДЫН ТОО, дүүргээр, 2024 онд
- ЗУРАГ 17. МАЛЧДЫН ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭЭ, насны бүлгээр, 2024 онд
- ЗУРАГ 18. СҮРГИЙН БҮТЭЦ
- ЗУРАГ 19. НИЙТ МАЛД БОД МАЛ, БОГ МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ, оноор
- ЗУРАГ 20. БОГ МАЛД ХОНЬ, ЯМААНЫ ЭЗЛЭХ ХУВЬ
- ЗУРАГ 21. ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО, оноор
- ЗУРАГ 22. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, оноор
- ЗУРАГ 23. ТӨЛ БОЙЖИЛТЫН ХУВЬ, дүүргээр
- ЗУРАГ 24. ОНЫ ЭХНИЙ МАЛД ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ, оноор
- ЗУРАГ 25. ШУВУУНЫ ТОО, оноор
- ЗУРАГ 26. ХУРААСАН УРГАЦ, төрлөөр

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
МАА	Мал аж ахуй
МИД	Малын индексжүүлсэн даатгал
ҮСХ	Үндэсний Статистикийн хороо
ХАА	Хөдөө аж ахуй
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн

НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

ХӨДӨӨ АЖ АХУЙ

Мал аж ахуй Малын жил бүрийн тооллого, мөн хашаа, худгийн болон бусад тооллого, судалгаа нь мал аж ахуйн салбарын мэдээллийн гол эх үүсвэр юм.

Мал тооллогыг зун, намрын улиралд буюу ихэвчлэн 8, 9 дүгээр сард явуулж байснаа 1961 оноос мал, тэжээвэр амьтдыг жилийн эцэст 12 дугаар сард тоолдог болов. Энэ хугацаа нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн жилтэй тохирдог, малын орлого, зарлага бүрэн гарч дууссан байдаг зэрэг давуу талтай. Малын тооллогын дүн нь зөвхөн мал, гэрийн тэжээвэр амьтдын тооны өсөлт, бууралтыг харуулах төдийгүй сүргийн нөхөн үйлдвэрлэлийн үзүүлэлтийг тодорхойлж судлах, шинжлэх бололцоог олгоно.

Хөдөө аж ахуйн салбарын боловсон хүчин, ашиглаж байгаа машин, техник, хашаа, худгийн тооллогыг 1996 оноос хойш гурван жил тутамд явуулж байна.

Мал бүхий өрх гэж малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрхийг ойлгоно.

Малчин өрхөд жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа өрхийг хамруулна.

Малтай өрх гэж мал бүхий өрх болон малчин өрхийг ойлгоно.

Бэлэн хээлтэгчид малын төрөл бүрээр нас гүйцсэн эм малыг хамруулна. Төлийн бойжилтын хувийг гаргахдаа бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Зүй бусаар хорогдсон малын тоонд халдвартай, халдваргүй өвчин, ган, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг гэнэтийн аюул болон араатан, жигүүртэнд идүүлэх, худаг, хавцалд унах зэрэг хариулга, маллагаатай холбоотой бусад шалтгаанаар хорогдсон малыг хамруулна.

ГАЗАР ТАРИАЛАН

Газар тариалан эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс тариалсан талбай, ургацын мэдээг баг, хорооны Засаг дарга нар цуглуулж, сум, дүүрэгт нэгтгэж, улмаар аймаг, нийслэлийн статистикийн байгууллагаар дамжин Үндэсний статистикийн хороонд нэгтгэн боловсруулж байна.

Гол төлөв төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн ургамал зэргийг тарьж ургуулдаг бөгөөд тэдгээрийн тариалсан талбай, ургац хураалт, орон нутгийн түвшинд тодорхойлно.

Хөдөө аж ахуйн эдэлбэр газарт бэлчээр, хадлан, тариалан, атаршсан газар, хөдөө аж ахуйн барилга, байгууламжийн дэвсгэр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулсан бусад газар хамаарна.

Тариалсан талбай гэж хөдөө аж ахуйн ургамал тариалсан талбайг хэлэх бөгөөд тухайн жилд үр суулгасан газрын нийт хэмжээгээр тодорхойлно.

Нийт хураасан ургац нь тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг таримал ургамлын хэмжээгээр тодорхойлогдоно.

Га-гийн ургац гэж талбайн нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ юм. Га-гийн ургацыг тодорхойлохдоо нэг төрлийн ургамал тариалсан талбайгаас хураан авсан бүх ургацыг тариалсан талбайн хэмжээнд нь харьцуулна.

ОРШИЛ

Манай улсын эдийн засагт хөдөө аж ахуйн салбар нь чухал байр суурь эзэлдэг. Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас хамааралтай бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хэрэглээ, боловсруулах үйлдвэрийн салбарын түүхий эдийг хангаж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд “Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна” гэснийг үндэслэн мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулдаг.

Мал аж ахуй нь амьжиргааны гол эх үүсвэр болсон анхдагч үйлдвэрлэлийн салбар байсны хувьд бүртгэл, статистикийн ажил салбараас эхлэн хөгжсөн түүхтэй.

Мал тооллогыг зун, намрын улиралд буюу ихэвчлэн 8,9 дүгээр сард явуулж байсан бол, 1961 оноос мал, тэжээвэр амьтдыг жилийн эцэст 12 дугаар сард тоолдог болсон. Энэ хугацаа нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн жилтэй тохирдог, малын орлого, зарлагын үзүүлэлт бүрэн гарч дууссан, малчид өвөлжөөндөө бууж, хүн, малын хөдөлгөөн харьцангуй бага байдаг зэрэг давуу талтай юм. Малын хашаа байрны тооллогыг 1966 оноос, худаг, малын тэжээлийн тооллогыг 1972 оноос нэмж мал тооллоготой хамтруулан явуулдаг болов. Ардын хувийн аж ахуйтны малыг 1959-1960 онд нийгэмчилж, хоршоололд хамруулж дууссан бол 1992 онд малыг хувьчлах ажил хийгдэж дууссан билээ.

Мал тооллогын 1992 оны дүнгээр манай улсад 25.7 сая толгой мал тоологдсон бол Нийслэлд 275.1 мянган толгой мал тоологдсон нь нийт дүнгийн 1 хувийг эзэлж байна.

Малын тооллогын үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, тухайн салбарын талаар бодлого боловсруулах, шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “В” заалт, “Мал, тэжээвэр амьтдын тооллогыг жил тутам, хашаа худгийн тооллогыг 3 жил тутам” зохион байгуулах тухай Монгол улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу Үндэсний статистикийн хорооны даргын чиглэл заавар, Нийслэлийн Засаг даргын захирамжийн хүрээнд 2024 оны жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллогыг Нийслэлийн хэмжээнд явуулан үр дүнг энэхүү танилцуулгаар Та бүхэнд хүргэж байна.


Мал тооллогын 2024 оны жилийн эцсийн дүнгээр 412849 толгой мал толгойд хүрч, 90200 толгой адуу, 90759 толгой үхэр, 133361 толгой хонь, 98402 толгой ямаа, 127 толгой тэмээ тоологдлоо.

Танилцуулгад Нийслэлийн дүн болон дүүргүүдийн дүн зэрэгцүүлэлт хийж харуулав.

Нийслэлийн хэмжээнд хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга, судалгааны материал нь суурь мэдээлэл болно гэдэгт итгэж байна.

НИЙСЛЭЛИЙН 2024 ОНЫ МАЛ ТООЛЛОГЫН ДҮН

НИЙТ МАЛЫН ТОО **412 849**



НИЙСЛЭЛИЙН 2024 ОНЫ ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО





НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН
ГАЗАР

БҮЛЭГ 1. МАЛ АЖ АХУЙ

I НИЙТ МАЛЫН ТОО

Нийслэлийн мал, тэжээвэр амьтдын 2024 оны тооллогоор нийт 412849 толгой мал тоологдсон нь өмнөх оноос 14335 толгой малаар (3.4%) буурсан байна. Улсын хэмжээнд тоологдсон 57.6 сая толгой малын 0.7 хувийг нийслэлийн мал эзэлж байна.

ЗУРАГ 1. НИЙТ МАЛЫН ТОО, улсын дүнтэй харьцуулснаар, оноор



Малын төрлөөр авч үзвэл адуу 90200 толгой, үхэр 90759 толгой, тэмээ 127 толгой, хонь 133361 толгой, ямаа 98402 толгой мал тус тус тоологдов. Өмнөх онтой харьцуулахад тэмээ


35.1 хувиар (33), адуу 14.9 хувиар (11730), үхэр 4.4 хувиар (3836) өсөж, хонь 14.3 хувиар (22243), ямаа 7.2 хувиар (7691) тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 1. НИЙТ МАЛЫН ТОО, малын төрлөөр

Төрөл	2020	2021	2022	2023	2024	Өөрчлөлт	
	толгой					Дүн	хувь
Бүгд	468 690	443 320	442 841	427 184	412 849	-14 335	-3.4
Тэмээ	245	125	131	94	127	33	35.1
Адуу	57 609	61 981	68 915	78 470	90 200	11 730	14.9
Үхэр	89 513	84 528	88 007	86 923	90 759	3 836	4.4
Хонь	174 896	169 006	164 325	155 604	133 361	-22 243	-14.3
Ямаа	146 427	127 680	121 463	106 093	98 402	-7 691	-7.2

2024 онд 3466 сарлаг тоологдсон нь нийт үхэр сүргийн 3.8 хувийг эзэлж байна. Сарлагийн тоо өмнөх оноос 10.5 хувь буюу 328 толгойгоор өссөн байна.

ЗУРАГ 2. САРЛАГИЙН ТОО, оноор



ХҮСНЭГТ 2.

МАЛЫН ТОО, дүүргээр

Дүүрэг	2020	2021	2022	2023	2024	Өөрчлөлт	
	толгой					Дүн	хувь
Бүгд	468 690	443 320	442 841	427 184	412 849	-14 335	-3.4
Багануур	194 501	182 583	170 805	169 438	162 098	-7 340	-4.3
Багахангай	27 496	25 656	26 184	28 406	30 028	1 622	5.7
Баянзүрх	59 804	59 425	67 886	59 295	55 467	-3 828	-6.5
Налайх	60 087	50 431	48 211	44 138	45 605	1 467	3.3
Сонгинохайрхан	80 712	82 358	83 687	73 824	70 188	-3 636	-4.9
Хан-Уул	46 090	42 867	46 068	52 083	49 463	-2 620	-5.0

Нийслэлийн хэмжээнд хамгийн их буюу 162098 толгой мал Налайх дүүрэгт, хамгийн бага буюу 30028 толгой мал Багахангай дүүрэгт тус тус тоологдсон байна.

ХҮСНЭГТ 3.

МАЛЫН ТОО, төрлөөр, дүүргээр

Төрөл	2020	2021	2022	2023	2024	Өөрчлөлт	
	толгой					дүн	хувь
Адуу, Бүгд	57 609	61 981	68 915	78 470	90 200	11 730	14.9
Багануур	15 294	15 137	15 545	17 412	19 099	1 687	9.7
Багахангай	3 033	3 280	3 319	4 275	4 901	626	14.6
Баянзүрх	7 482	8 862	10 873	12 415	14 412	1 997	16.1
Налайх	9 348	8 980	9 830	10 478	13 916	3 438	32.8
Сонгинохайрхан	10 492	13 125	13 926	15 838	18 343	2 505	15.8
Хан-Уул	11 960	12 597	15 422	18 052	19 529	1 477	8.2
Үхэр, Бүгд	89 513	84 528	88 007	86 923	90 759	3 836	4.4
Багануур	18 067	17 327	16 278	18 076	20 434	2 358	13.0
Багахангай	2 847	2 654	2 607	2 716	3 128	412	15.2
Баянзүрх	18 918	17 097	18 586	17 583	17 176	-407	-2.3
Налайх	13 424	11 988	11 479	10 355	11 037	682	6.6
Сонгинохайрхан	24 357	24 248	26 764	25 712	25 826	114	0.4
Хан-Уул	11 900	11 214	12 293	12 481	13 158	677	5.4
Тэмээ, Бүгд	245	125	131	94	127	33	35.1
Багануур	205	81	54	50	49	-1	-2.0
Багахангай	9	7	5	7	8	1	14.3
Баянзүрх	-	-	-	-	-	-	-
Налайх	24	15	30	26	40	14	53.8
Сонгинохайрхан	-	11	23	3	2	-1	-33.3
Хан-Уул	7	11	19	8	28	20	3.5**
Хонь, Бүгд	174 896	169 006	164 325	155 604	133 361	-22 243	-14.3
Багануур	92 137	90 373	84 995	82 410	71 973	-10 437	-12.7
Багахангай	12 051	11 190	11 714	13 304	13 659	355	2.7
Баянзүрх	17 171	18 200	20 903	17 910	14 159	-3 751	-20.9
Налайх	21 567	17 929	16 638	13 983	11 911	-2 072	-14.8
Сонгинохайрхан	21 739	21 688	20 917	17 130	12 669	-4 461	-26.0
Хан-Уул	10 231	9 626	9 158	10 867	8 990	-1 877	-17.3
Ямаа, Бүгд	146 427	127 680	121 463	106 093	98 402	-7 691	-7.2
Багануур	68 798	59 665	53 933	51 490	50 543	-947	-1.8
Багахангай	9 556	8 525	8 539	8 104	8 332	228	2.8
Баянзүрх	16 233	15 266	17 524	11 387	9 720	-1 667	-14.6
Налайх	15 724	11 519	10 234	9 296	8 701	-595	-6.4
Сонгинохайрхан	24 124	23 286	22 057	15 141	13 348	-1 793	-11.8
Хан-Уул	11 992	9 419	9 176	10 675	7 758	-2 917	-27.3

** дахин их

Өмнөх онтой харьцуулахад Багахангай дүүргийн мал 5.7 хувиар (1622), Налайх дүүргийн мал 3.3 хувиар (1467) өсөж, Багануур дүүргийн мал 4.3 хувиар (7340), Баянзүрх дүүргийн мал 6.5 хувиар (3828), Сонгинохайрхан дүүргийн мал 4.9 хувиар (3636), Хан-Уул дүүргийн мал 5.0 хувиар (2620) тус тус буурсан байна. Хонины тоо толгой 14.3

хувиар (22243) буурахад Багануур дүүрэгт 12.7 хувиар (10437), Сонгинохайрхан дүүрэгт 26.0 хувиар (4461) буурсан нь голлон нөлөөлсөн бол ямааны тоо толгой 7.2 хувиар (7691) буурахад Хан-Уул дүүрэгт 27.3 хувиар (2917), Баянзүрх дүүрэгт 14.6 хувиар (1667) буурсан нь голлон нөлөөлжээ.

1.1 Өрхийн болон аж ахуйн нэгж, байгууллагын малын тоо

Нийслэлийн хэмжээнд 2024 онд тоологдсон 412849 толгой малын 98.4 хувь нь буюу 406079 толгой мал нь өрхийн аж ахуй, 0.6 хувь нь буюу 6770 толгой нь аж ахуйн нэгж байгууллагын тоолуулсан мал байна.

Өрхийн аж ахуйн буюу хувийн малын тоо 2024 онд 406079 толгой болж, өмнөх оноос 14477 толгой буюу 3.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Өрхийн аж ахуйн малын 22.0 хувийг адуу, 21.8 хувийг үхэр, 32.1 хувийг хонь, 24.0 хувийг ямаа, 0.1 хувийг тэмээ эзэлж байна.

ХҮСНЭГТ 4. ӨРХИЙН АЖ АХУЙН БУЮУ ХУВИЙН МАЛЫН ТОО, төрлөөр

Төрөл	2020	2021	2022	2023	2024	Өөрчлөлт	
	Толгой					Дүн	Хувь
Бүгд	459 323	434 964	435 967	420 556	406 079	-14 477	-3.4
Тэмээ	245	125	131	92	125	33	35.9
Адуу	56 769	60 998	67 723	77 571	89 506	11 935	15.4
Үхэр	88 328	82 726	86 172	84 967	88 576	3 609	4.2
Хонь	169 398	164 897	161 671	153 192	130 528	-22 664	-14.8
Ямаа	144 583	126 218	120 270	104 734	97 344	-7 390	-7.1

Өрхийн аж ахуйн нийт малын 39.5 хувь нь Багануур дүүрэгт, 7.4 хувь нь Багахангай дүүрэгт, 13.6 хувь нь Баянзүрх дүүрэгт, 11.0 хувь нь Налайх дүүрэгт, 16.4 хувь нь Сонгинохайрхан дүүрэгт, 12.1 хувь нь Хан-Уул дүүрэгт тус тус тоологдсон байна.

ХҮСНЭГТ 5. ӨРХИЙН АЖ АХУЙН БУЮУ ХУВИЙН МАЛЫН ТОО, дүүргээр

Дүүрэг	2020	2021	2022	2023	2024	Өөрчлөлт	
	толгой					Дүн	Хувь
Бүгд	459 323	434 964	435 967	420 556	406 079	-14 477	-3.4
Багануур	189 859	179 845	169 083	168 086	160 385	-7 701	-4.6
Багахангай	27 496	25 656	26 184	28 406	30 028	1 622	5.7
Баянзүрх	59 505	58 935	67 851	59 215	55 327	-3 888	-6.6
Налайх	59 439	49 422	47 791	43 480	44 709	1 229	2.8
Сонгинохайрхан	77 221	78 818	79 891	70 125	66 543	-3 582	-5.1
Хан-Уул	45 803	42 288	45 167	51 244	49 087	-2 157	-4.2

Аж ахуйн нэгж, байгууллагын малын тоо 2024 онд 6770 болж өмнөх оноос 2.1 хувиар буюу 142 толгой малаар өссөн байна. Нийт аж ахуйн нэгжийн тоолуулсан малын 10.3 хувийг адуу, 32.2 хувийг үхэр, 41.8 хувийг хонь, 15.6 хувийг ямаа 0.1 хувийг тэмээ эзэлж байна.

ХҮСНЭГТ 6.

АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН МАЛЫН ТОО, төрлөөр

Төрөл	2020	2021	2022	2023	2024	Өөрчлөлт	
	толгой					Дүн	Хувь
Бүгд	9 367	8 356	6 874	6 628	6 770	142	2.1
Тэмээ	-	-	-	2	2	-	-
Адуу	840	983	1 192	899	694	-205	-22.8
Үхэр	1 185	1 802	1 835	1 956	2 183	227	11.6
Хонь	5 498	4 109	2 654	2 412	2 833	421	17.5
Ямаа	1 844	1 462	1 193	1 359	1 058	-301	-22.1

1.2 Малтай өрхийн малын бүлэглэлт

Жилийн эцсийн мал тэжээвэр амьтдын тооллогоор 5554 малтай өрхийн 406.1 мянган толгой мал тоологдсон байна. 2024 оны эцэст нийслэлд нийт 475.1 мянган өрх бүртгэгдсэний 1.2 хувь нь малтай өрх байв.

2024 онд 5554 малтай өрх малаа тоолуулсан нь өмнөх онтой харьцуулах 3.9 хувиар буюу 206 өрхөөр нэмэгдсэн байна. Малтай өрхийг малын тооны бүлэглэлтээр авч үзвэл 11 хүртэлх малтай өрх 24.2 хувийг, 11-30 тооны малтай өрх 29.3 хувийг, 31-50 тооны малтай өрх 14.2 хувийг, 51-100 тооны малтай өрх 14.4

хувийг, 101-200 тооны малтай өрх 8.9 хувийг, 201-500 тооны малтай өрх 7.0 хувийг, 501-999 тооны малтай өрх 1.5 хувийг, 1000-1499 тооны малтай өрх 0.4 хувийг, 1500 болон түүнээс дээш тооны малтай өрх 0.1 хувийг тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 7.

МАЛТАЙ ӨРХИЙН МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ, өрхийн тоогоор

Малын тооны бүлэглэлт	2020	2021	2022	2023	2024	Өөрчлөлт	
	Малтай өрхийн тоо					Дүн	Хувь
Бүгд	5 006	5 120	5 236	5 348	5 554	206	3.9
11 хүртэлх	1 261	1 341	1 355	1 321	1 346	25	1.9
11-30	1 399	1 433	1 449	1 544	1 628	84	5.4
31-50	590	654	657	726	787	61	8.4
51-100	634	622	722	728	799	71	9.8
101-200	502	511	493	480	495	15	3.1
201-500	441	395	408	418	390	-28	-6.7
501-999	137	118	113	102	81	-21	-20.6
1000-1499	31	37	33	26	26	0	0.0
1500+	11	9	6	3	2	-1	-33.3

Малтай 5554 өрхийг малын тоогоор бүлэглэвэл 11 хүртэлх малтай 1346 өрхийн 7934 толгой мал, 11-30 хүртэлх малтай 1628 өрхийн 31648 толгой мал, 31-50 хүртэлх малтай 787 өрхийн 31145 толгой мал, 51-100 хүртэлх малтай 799 өрхийн 56420 толгой мал, 101-200 хүртэлх малтай 495 өрхийн 70132

толгой мал, 201-500 хүртэлх малтай 390 өрхийн 117957 толгой мал, 501-999 хүртэлх малтай 81 өрхийн 55821 толгой мал, 1000-1499 хүртэлх малтай 26 өрхийн 29541 толгой мал, 1500 болон түүнээс дээш малтай 2 өрхийн 5481 толгой мал тус тус тоологдсон байна.

ХҮСНЭГТ 8.

МАЛТАЙ ӨРХИЙН МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ, малын тоогоор

Малын тооны бүлэглэлт	Малтай өрхийн тоо		Малын тоо, толгой						
	2023	2024	2023	2024	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Бүгд	5 348	5 554	420 556	406 079	125	89 506	88 576	130 528	97 344
10 хүртэлх	1 321	1 346	7 653	7 934	6	1 165	6 573	85	105
11-30	1544	1 628	29 480	31 648	13	9 905	19 343	1 151	1 236
31-50	726	787	28 739	31 145	16	11 814	14 826	2 266	2 223
51-100	728	799	51 942	56 420	12	22 544	17 511	8 665	7 688
101-200	480	495	67 960	70 132	15	21 159	13 307	19 024	16 627
201-500	418	390	127 638	117 957	22	15 400	10 678	51 990	39 867
501-999	102	81	70 114	55 821	31	4 001	2 779	29 126	19 884
1000-1499	26	26	30 672	29 541	0	2 368	1 809	16 220	9 144
1500+	3	2	6 358	5 481	10	1 150	1 750	2 001	570

1.3 Малчин өрхийн малын бүлэглэлт

Малтай нийт өрхийн 3729 (67.1%) нь жилийн дөрвөн улирлын туршид малаа малладаг, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж буй малчин өрхүүд, 1825 өрх Малчин өрхийг малын тоо толгойгоор бүлэглэвэл 11 хүртэлх малтай 715 өрхийн 4 417 толгой мал, 11-30 хүртэлх малтай 1 112 өрхийн 21 782 толгой мал, 31-50 хүртэлх малтай 566 өрхийн 22 269 толгой мал, 51-100 хүртэлх малтай 536 өрхийн 38 036 толгой мал, 101-200 хүртэлх малтай 389 өрхийн 55 699

(32.9%) нь малыг амьдрал ахуйдаа туслах чанартайгаар өсгөн үржүүлж буй мал бүхий өрхүүд байна.

толгой мал, 201-500 хүртэлх малтай 309 өрхийн 93 947 толгой мал, 500-999 хүртэлх малтай 74 өрхийн 50 169 толгой мал, 1000-1499 хүртэлх малтай 26 өрхийн 29 541 толгой мал, 1500 болон түүнээс дээш малтай 2 өрхийн 5481 толгой мал тус тус тоологдсон байна.

ХҮСНЭГТ 9.

МАЛЧИН ӨРХИЙН МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ, малын төрлөөр

Малын тооны бүлэглэлт	Малчин өрхийн тоо		Малын тоо, толгой						
	2023	2024	2023	2024	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Бүгд	3 346	3 729	326 017	321 341	76	59 316	70 257	109 152	82 540
10 хүртэлх	567	715	3 533	4 417	-	542	3 792	33	50
11-30	963	1 112	18 661	21 782	4	5 701	14 823	594	660
31-50	506	566	20 121	22 269	14	7 140	12 216	1 359	1 540
51-100	507	536	36 183	38 036	9	13 399	14 181	5 284	5 163
101-200	356	389	50 516	55 699	15	14 610	11 433	15 439	14 202
201-500	328	309	101 307	93 947	-	10 951	7 829	41 978	33 189
501-999	93	74	64 037	50 169	24	3 455	2 424	26 244	18 022
1000-1499	24	26	28 241	29 541	-	2 368	1 809	16 220	9 144
1500+	2	2	3 418	5 481	10	1 150	1 750	2 001	570

Өмнөх онтой харьцуулахад 501-999 хүртэлх малтай өрх 20.4 хувиар (19), 201-500 хүртэлх малтай өрх 5.8 хувиар (19) буурсан бол 31-50 хүртэлх малтай өрх 11.9 хувиар (60), 11-30 хүртэлх малтай өрх 15.5 хувиар (149), 11

хүртэлх малтай өрх 26.1 хувиар (148) өссөн байна. Малчин өрхийн тоо өмнөх оноос 11.4 хувиар (383) өссөн боловч нэг өрхийн маллах малын тоо буурсан үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 10.

МАЛЧИН ӨРХИЙН МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ, өрхийн тоогоор

Малын тооны бүлэглэлт	2020	2021	2022	2023	2024	Өөрчлөлт	
	Малчин өрхийн тоо					Дүн	Хувь
Бүгд	2 879	3 022	3 313	3 346	3 729	383	11.4
10 хүртэлх	438	513	575	567	715	148	26.1
11-30	836	856	942	963	1112	149	15.5
31-50	366	422	451	506	566	60	11.9
51-100	403	395	498	507	536	29	5.7
101-200	332	369	363	356	389	33	9.3
201-500	349	324	345	328	309	-19	-5.8
501-999	116	100	103	93	74	-19	-20.4
1000-1499	29	35	31	24	26	2	8.3
1500+	10	8	5	2	2	-	-

II МАЛТАЙ БОЛОН МАЛЧИН ӨРХ, ТЭДГЭЭРИЙН СОЁЛ, АХУЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2.1 Малтай өрх, малчин өрхийн тоо, байршил

Нийслэлийн хэмжээнд 2024 оны эцэст 475.1 мянган өрх бүртгэгдсэний 5.5 мянган өрх буюу 1.2 хувь нь малтай өрх байна. Нийт малтай өрхийн 67.1 хувь нь буюу 3 729 өрх нь жилийн дөрвөн улирлын туршид малаа малладаг малчин өрх байна.

Нийт малтай өрхийн хамгийн их нь буюу 1624 өрх нь Сонгинохайрхан дүүрэгт тооллогд хамрагдсан бол, хамгийн бага нь Багахангай дүүрэгт 262 өрх малаа тоолуулсан байна.

Налайх дүүрэгт 57 өрх, Сонгинохайрхан дүүрэгт 46 өрх, Багануур дүүрэгт 53 өрх, Хан-Уул дүүрэгт 18 өрх, Баянзүрх дүүрэгт 16, Багахангай дүүрэгт 16 өрх тус тус нэмэгджээ.

ХҮСНЭГТ 11.

МАЛТАЙ ӨРХИЙН ТОО, дүүргээр

Дүүрэг	2020	2021	2022	2023	2024	Өөрчлөлт	
	Малтай өрхийн тоо					Дүн	Хувь
Бүгд	5 006	5 120	5 236	5 348	5 554	206	3.9
Багануур	812	834	834	905	958	53	5.9
Багахангай	234	236	226	246	262	16	6.5
Баянзүрх	1 044	1 005	1 061	1 056	1 072	16	1.5
Налайх	778	777	747	774	831	57	7.4
Сонгинохайрхан	1 409	1 504	1 566	1 578	1 624	46	2.9
Хан-Уул	729	764	802	789	807	18	2.3

Нийт малчин өрхийн 1250 өрх нь (33.5%) Сонгинохайрхан дүүрэгт, 904 өрх (24.2%) нь Баянзүрх дүүрэгт, 675 өрх нь (18.1%) Багануур дүүрэгт, 531 өрх нь (14.2%) Налайх дүүрэгт, 267 өрх нь (7.2%) Хан-Уул дүүрэгт, 102 өрх нь (2.7%) Багануур дүүрэгт тус тус тоологдсон байна. Өмнөх онтой харьцуулахад малчин өрхийн тоо

Сонгинохайрхан дүүрэгт 280 (28.9%) өрхөөр, Хан-Уул дүүрэгт 25 (10.3%) өрхөөр, Багануур дүүрэгт 41(6.5%) өрхөөр, Налайх дүүрэгт 67 (14.4%) өрхөөр өссөн бол, Багахангай дүүрэгт 12 (10.5%) өрхөөр, Баянзүрх дүүрэгт 67 (14.4%) өрхөөр тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 12.

МАЛЧИН ӨРХИЙН ТОО, дүүргээр

Дүүрэг	2020	2021	2022	2023	2024	Өөрчлөлт	
	Өрхийн тоо					Дүн	Хувь
Бүгд	2 879	3 022	3 313	3 346	3 729	383	11.4
Багануур	569	571	603	634	675	41	6.5
Багахангай	87	86	102	114	102	-12	-10.5
Баянзүрх	742	783	920	922	904	-18	-2.0
Налайх	459	510	478	464	531	67	14.4
Сонгинохайрхан	812	853	952	970	1 250	280	28.9
Хан-Уул	210	219	258	242	267	25	10.3

Нийслэлийн хэмжээнд нийт өрхөд малчин өрхийн эзлэх хувийг сүүлийн 10 жилээр авч үзвэл 2015 онд хамгийн бага буюу 24.4 хувийг, 2024 онд 67.1 хувийг эзэлж байна. Графикаас харахад нийслэлийн нутаг дэвсгэрт мал аж ахуй эрхэлж байгаа малчин өрхийн тоо жил бүр өссөн үзүүлэлттэй байна.

ЗУРАГ 3.

НИЙТ ӨРХӨД МАЛЧИН ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, оноор



2024 оны байдлаар нийт малтай өрхөд, малчин өрхийн эзлэх хувийг хороогоор авч үзвэл Багануур дүүргийн 2 болон 4 дүгээр хороо, Баянзүрх дүүргийн 35 болон 20 дугаар хороо, Сонгинохайрхан дүүргийн 33 болон 34 дүгээр

хороодын дийлэнх буюу 90-ээс дээш хувийг малчин өрх эзэлж байна. Харин Налайх дүүргийн 3 дугаар хорооны малтай өрхийн дөнгөж 6.4 хувь нь малчин өрх байна.

ХҮСНЭГТ 13.


МАЛ БҮХИЙ ӨРХИЙН ТОО, дүүргээр

Дүүрэг	2020	2021	2022	2023	2024	Өөрчлөлт	
	Мал бүхий өрхийн тоо					Дүн	Хувь
Бүгд	2 102	2 069	1 897	1 977	1 799	-178	-9.0
Багануур	240	260	231	271	283	12	4.4
Багахангай	147	150	124	132	160	28	21.2
Баянзүрх	299	222	141	132	168	36	27.3
Налайх	314	255	257	293	282	-11	-3.8
Сонгинохайрхан	594	642	605	604	367	-237	-39.2
Хан-Уул	508	540	539	545	539	-6	-1.1

Мал бүхий өрхийн тоо өмнөх онтой харьцуулахад 178 өрхөөр (9.0%) буурсан байна. Нийт малтай өрхийн 32.4 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 4.

МАЛ БҮХИЙ ӨРХИЙН ТОО, дүүргээр



ХҮСНЭГТ 14.

МАЛТАЙ БОЛОН МАЛЧИН ӨРХ, дүүрэг, хороогоор

Дүүрэг, хороо	2020		2021		2022		2023		2024	
	Малтай өрхийн тоо	Малчин өрхийн тоо	Малтай өрхийн тоо	Малчин өрхийн тоо	Малтай өрхийн тоо	Малчин өрхийн тоо	Малтай өрхийн тоо	Малчин өрхийн тоо	Малтай өрхийн тоо	Малчин өрхийн тоо
Бүгд	5 006	2 879	5 120	3 022	5 236	3 313	5 348	3 346	5 554	3 729
Багануур	812	569	834	571	834	603	905	634	958	675
1-р хороо	170	99	176	89	166	89	180	97	188	98
2-р хороо	94	93	80	77	75	75	79	76	82	81
3-р хороо	166	63	162	72	166	74	186	77	197	101
4-р хороо	199	195	212	212	221	220	245	230	257	238
5-р хороо	183	119	204	121	206	145	215	154	234	157
Багахангай	234	87	236	86	226	102	246	114	262	102
1-р хороо	105	52	111	46	109	44	121	69	127	60
2-р хороо	129	35	125	40	117	58	125	45	135	42
Баянзүрх	1044	742	1005	783	1061	920	1056	922	1072	904
33-р хороо	-	-	-	-	264	221	270	229	278	218
35-р хороо	-	-	-	-	236	235	268	266	269	266
11-р хороо	204	109	201	120	215	145	205	141	213	139
20-р хороо	840	633	804	663	346	319	313	286	312	281
Налайх	778	459	777	510	747	478	774	464	831	531
1-р хороо	106	76	113	97	111	66	116	63	135	79
2-р хороо	13	3	11	4	-	-	-	-	-	-
3-р хороо	118	76	119	81	135	90	135	89	156	123
4-р хороо	123	39	123	30	75	13	89	15	94	6
5-р хороо	144	85	142	101	166	126	164	124	173	137
6-р хороо	201	149	214	172	230	173	229	158	231	174
7-р хороо	50	19	25	9	22	6	24	6	28	5
8-р хороо	23	12	30	16	8	4	17	9	14	7
Сонгинохайрхан	1409	812	1504	853	1566	952	1578	970	1624	1250
32-р хороо	197	167	199	178	204	135	203	161	193	165
33-р хороо	21	21	27	27	35	33	28	28	26	26
34-р хороо	10	7	12	11	15	14	17	16	16	16
36-р хороо	-	-	-	-	3	-	2	-	1	-
41-р хороо	1	-	-	-	-	-	-	-	-	-
21-р хороо	1 180	617	1 266	637	1 309	770	1 328	765	1 388	1 043
Хан-Уул	729	210	764	219	802	258	789	242	807	267
12-р хороо	89	55	88	54	96	56	88	56	95	55
13-р хороо	268	104	286	102	291	137	288	128	290	130
14-р хороо	372	51	390	63	415	65	413	58	422	82

Нийт мал бүхий 1799 өрхийн Хан-Уул дүүрэгт 30 хувь нь, Сонгинохайрхан дүүрэгт 20.4 хувь нь, Налайх дүүрэгт 15.7 хувь нь, Багануур

дүүрэгт 15.7 хувь нь, Баянзүрх дүүрэгт 9.3 хувь нь, Багахангай дүүрэгт 8.9 хувь нь тус тус малаа тоолуулсан байна.

ЗУРАГ 5. НИЙТ МАЛТАЙ ӨРХӨД, ТАВИУЛ МАЛТАЙ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, оноор



Нийслэлийн хэмжээнд 2024 онд 26 тавиул малтай малаа тоолуулсан байна. Энэ нь нийт малтай өрхийн 0.5 хувийг эзэлж байна.

2.2 Малчин өрхийн ам бүл

Нийслэлд 2024 оны байдлаар нийт хүн амын 1.2 хувь буюу 19428 хүн малчин өрхөд амьдарч байгаа бөгөөд нэг малчин өрхөд дунджаар 3-4 хүн амьдардаг байна. Хүснэгтэд малчин өрхийн ам бүлийн дийлэнх нь буюу 12466

(64.2%) нь 10-100 хүртэлх малтай өрхөд, 101-999 хүртэлх малтай өрхөд 6865 (35.5%), 1000-2001 болон түүнээс дээш малтай өрхөд 97 (0.5%) нь тус тус амьдарч байна.

ХҮСНЭГТ 15.

МАЛЧИН ӨРХ, МАЛЧИН ӨРХИЙН АМ БҮЛ, НЭГ ӨРХӨД НОГДОХ МАЛЫН ТОО, 2024 онд, малын тооны бүлэглэлтээр

Малын тооны бүлэглэлтээр	Өрхийн тоо	Нийт малчин өрхөд эзлэх хувь	Малчин өрхийн ам бүлийн тоо	Нэг өрхөд ногдох ам бүлийн тоо	Малчин өрхийн малын тоо	Малын тооны эзлэх хувь	Нэг өрхөд ногдох малын тоо	Өрхийн нэг хүнд ногдох малын тоо
Бүгд	5 554	100	19 428	3.5	406 079	100	38.2	20.9
10 хүртэлх	1 346	24.2	4 250	3.2	7 934	2.0	5.8	1.9
11-30	1 628	29.3	5 434	3.3	31 648	7.8	18.2	5.8
31-50	787	14.2	2 782	3.5	31 145	7.7	34.7	11.2
51-100	799	14.4	3 008	3.8	56 420	13.9	53.2	18.8
101-200	495	8.9	1 915	3.9	70 132	17.3	80.3	36.6
201-500	390	7.0	1 592	4.1	117 957	29.0	101.9	74.1
501-999	81	1.5	350	4.3	55 821	13.7	174.9	159.5
1000-1499	26	0.5	89	3.4	29 541	7.3	308.6	331.9
2001-с дээш	2	0.0	8	4.0	5 481	1.3	1 659.9	685.1

2.3 Малчин өрхийн зарим үзүүлэлт

Мал тооллогын 2024 оны дүнгээр малчин өрхийн 86.6 хувь нь цахилгаан эх үүсгүүртэй, 80.1 хувь нь телевизортой, 79.9 хувь нь автомашинтай, 27.0 хувь нь мотоциклтой байна.

Телевизортой өрхийн тоо 2024 онд 2 988 болж, өмнөх оноос 1.3 (350) хувиар, автомашинтай өрхийн тоо 2 979 болж, өмнөх оноос 9.6 (626) хувиар, мотоциклтой өрх 1007 болж, өмнөх

оноос 4.0 (236) хувиар тус тус өссөн байна. Цахилгаан үүсгүүртэй өрхийн тоо 2024 онд 3230 болж, өмнөх оноос 331 өрхөөр нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 16.

МАЛЧИН ӨРХИЙН СОЁЛ АХУЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	Малчин өрхийн тоо					Малчин өрхийн дүнд эзлэх хувь				
	2020	2021	2022	2023	2024	2020	2021	2022	2023	2024
Цахилгаан үүсгүүртэй	2 326	2 492	2 721	2 899	3 230	80.8	82.5	82.1	86.6	86.6
Телевизортой	2 001	2 330	2 462	2 638	2 988	69.5	77.1	74.3	78.8	80.1
Автомашинтай	1 530	2 394	1 987	2 353	2 979	53.1	79.2	60.0	70.3	79.9
Мотоциклтой	575	819	721	771	1 007	20.0	27.1	21.8	23.0	27.0

III МАЛЧДЫН МЭДЭЭЛЭЛ

3.1 Малчдын тоо


Нийслэлийн хэмжээнд 2024 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 5067 малчид мал аж ахуй эрхэлж байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад 13.1 (586) хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Малчдын тоог дүүргээр авч үзвэл Сонгинохайрхан дүүргийн малчдын тоо 30.3 (398) хувиар, Налайх дүүргийн малчдын тоо 19.6 (119) хувиар, Хан-Уул дүүргийн малчдын тоо 8.3 (28) хувиар, Багануур дүүргийн

малчдын тоо 8.1 (72) хувиар өссөн бол, Багахангай дүүргийн малчдын тоо 7.5 (10) хувиар, Баянзүрх дүүргийн малчдын тоо 1.8 (21) хувиар буурсан байна.

ЗУРАГ 6.

МАЛЧДЫН ТОО, 2024 онд, дүүргээр



Нийт малчдын 33.8 хувь нь Сонгинохайрхан дүүрэгт, 23.3 хувь нь Баянзүрх дүүрэгт, 19.0 хувь нь Багануур дүүрэгт, 14.3 хувь нь Налайх дүүрэгт, 7.2 хувь нь Хан-Уул дүүрэгт, 2.4 хувь Багахангай дүүрэгт тус тус мал аж ахуй эрхэлж байна.

ХҮСНЭГТ 17.

МАЛЧДЫН ТОО, дүүргээр


Дүүрэг	2020	2021	2022	2023	2024	Өөрчлөлт	
	Малчдын тоо					дүн	хувь
Бүгд	3 781	4 050	4 438	4 481	5 067	586	13.1
Багануур	847	872	857	889	961	72	8.1
Багахангай	115	114	129	133	123	-10	-7.5
Баянзүрх	835	989	1 147	1 199	1 178	-21	-1.8
Налайх	587	653	633	608	727	119	19.6
Сонгинохайрхан	1 104	1 104	1 304	1 315	1 713	398	30.3
Хан-Уул	293	318	368	337	365	28	8.3

3.2 Малчдын нас, хүйс

Нийслэлийн хэмжээнд 2024 онд бүртгэгдсэн нийт малчдын 16.9 (857) хувийг 15-34 насны залуу малчид, 60.5 (3067) хувийг 35-59 насны малчид, үлдсэн 22.6 (1143) хувийг 60-аас дээш настай малчид эзэлж байна. Өнгөрсөн онтой харьцуулахад залуу малчдын тоо 14.3 (107) хувиар нэмэгдсэн байна.

Нийт малчдад залуу малчдын эзлэх хувийн жин өмнөх онтой харьцуулахад 0.2 хувиар, 60-аас дээш насны малчдын эзлэх хувийн жин 2.1 хувиар өссөн бол 35-59 насны малчдын эзлэх хувийн жин 2.3 хувиар буурсан байна.

ЗУРАГ 7. МАЛЧДЫН НАСНЫ БҮТЭЦ, хувиар




Нийт малчдын 3192 буюу 63.0 хувь нь эрэгтэй, 1875 буюу 37.0 хувь нь эмэгтэй малчид байна. Өмнөх онтой харьцуулахад эрэгтэй малчдын тоо 11.9 (340) хувиар, эмэгтэй малчдын тоо 15.1 (246) хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2016-2020 онуудад эрэгтэй малчдын эзлэх хувь нэмэгдэж, эмэгтэй малчдын эзлэх хувь буурсан бол 2021-2024 онуудад эрэгтэй малчдын эзлэх хувь буурч, эмэгтэй малчдын

эзлэх хувь өсөх хандлагатай байна. 2024 онд эрэгтэй малчдын эзлэх хувь 0.6 хувиар буурсан бол, эмэгтэй малчдын эзлэх хувь 0.6 хувиар өссөн байна.

ЗУРАГ 8. МАЛЧДЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, нийт малчдын дүнд эзлэх хувиар




3.3 Үндсэн болон туслах малчин

Мал аж ахуй эрхэлдэг малчдын 4431 буюу 87.4 хувь нь үндсэн малчин, 636 буюу 12.6 хувь нь туслах малчид байна. 15-24 насны малчдын 79.5 хувь нь үндсэн малчин бол, 20.5 хувь нь туслах малчин эзэлж байхад, 25 наснаас дээш насны бүлгүүдэд үндсэн малчин 86.6 хувиас дээш хувийг эзэлж байна.

ЗУРАГ 9.

ҮНДСЭН БОЛОН ТУСЛАХ МАЛЧНЫ ХАРЬЦАА, насны бүлгээр, эзлэх хувиар, 2024 онд




Нийт малчдыг дүүргээр авч үзвэл Сонгинохайрхан дүүрэгт үндсэн малчдын 36.1 (1599) хувь нь, Баянзүрх дүүрэгт 22.8 (1 012) хувь нь, Багануур дүүрэгт 18.2 (808) хувь нь, Налайх дүүрэгт 13.3 (591) хувь нь, Хан-Уул дүүрэгт 6.9 (307) хувь нь, Багахангай дүүрэгт 2.7 (114) хувь нь тус тус бүртгэлтэй байна.

Харин туслах малчдын 24.1 (153) хувь нь Багануур дүүрэгт, 26.1(166) хувь нь Баянзүрх дүүрэгт, 21.4(136) хувь нь Налайх дүүрэгт, 17.9 (114) хувь нь Сонгинохайрхан дүүрэгт, 9.1(58) хувь нь Хан-Уул дүүрэгт, 1.4 (9) хувь нь Багахангай дүүрэгт бүртгэлтэй байна.

ЗУРАГ 10.

ҮНДСЭН БОЛОН ТУСЛАХ МАЛЧИД, дүүргээр



3.4 Малчдын боловсролын мэдээлэл

Малчдын боловсролын түвшинг 2024 оны байдлаар авч үзэхэд 13.2 хувь нь дээд боловсролтой, 10.1 хувь нь техникийн болон тусгай мэргэжлийн, 52.8 хувь нь бүрэн дунд, 17.1 хувь нь суурь, 5.2 хувь нь бага, 1.6 хувь нь боловсролгүй байна.


ХҮСНЭГТ 18.**МАЛЧДЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, насны бүлгээр, 2024 онд**

Насны бүлэг	Бүгд	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон тусгай мэргэжлийн	Дээд
Бүгд	5 067	80	261	866	2 675	514	671
15-24	185	7	15	40	89	26	8
25-34	672	14	30	90	328	63	147
35-44	1 302	24	81	190	696	66	245
45-54	1 424	15	44	265	852	118	130
55-64	967	16	42	180	497	161	71
65+	517	4	49	101	213	80	70
Дүнд эзлэх хувь							
Бүгд	100.0	1.6	5.2	17.1	52.8	10.1	13.2
15-24	100.0	3.8	8.1	21.6	48.1	14.1	4.3
25-34	100.0	2.1	4.5	13.4	48.8	9.4	21.9
35-44	100.0	1.8	6.2	14.6	53.5	5.1	18.8
45-54	100.0	1.1	3.1	18.6	59.8	8.3	9.1
55-64	100.0	1.7	4.3	18.6	51.4	16.6	7.3
65+	100.0	0.8	9.5	19.5	41.2	15.5	13.5

Малчдын боловсролын түвшинг насны бүлгээр авч үзвэл 15-34 насны нийт 857 залуу малчдын 22.8 хувь нь суурь болон түүнээс доош боловсролтой, 59.0 хувь нь техникийн болон тусгай мэргэжлийн, бүрэн дунд боловсролтой, 18.2 хувь нь дээд боловсролтой байна.

Харин 35-55 насны малчдын хувьд 22.7 хувь нь суурь болон түүнээс доош боловсролтой, 63.5 хувь нь техникийн болон тусгай мэргэжлийн, бүрэн дунд боловсролтой, 13.7 хувь нь дээд боловсролтой байна. 55-аас дээш настай малчдын хувьд 26.4 хувь нь

суурь болон түүнээс доош боловсролтой, 64.1 хувь нь техникийн болон тусгай мэргэжлийн, бүрэн дунд боловсролтой, 9.5 хувь нь дээд боловсролтой байна. Нас ахих тусам дээд боловсролтой малчдын тоо буурах хандлагатай байна.


ЗУРАГ 11.**МАЛЧДЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, 2024 он, хүйсээр**

Боловсролгүй малчдыг насны бүлгээр өмнөх онтой харьцуулахад, 25-34 насны боловсролгүй малчид 13.2 хувиар, 35-44 насны малчид 3.3 хувиар буурсан бол, 15-24 насны малчдын эзлэх хувь 0.8 хувиар, 45-54 насны

малчдын эзлэх хувь 0.1 хувиар, 55-64 насны малчдын эзлэх хувь 12.0 хувиар, 65-аас дээш насны малчдын эзлэх хувь 3.7 хувиар тус тус өссөн байна.

ЗУРАГ 12.

БОЛОВСРОЛГҮЙ МАЛЧИД, насны бүлгээр, дүнд эзлэх хувиар



Бага боловсролтой малчдын 184 буюу 70.5 хувийг эрэгтэй, 77 буюу 29.5 хувийг эмэгтэй малчид эзэлж байна. Насны бүлгээр авч үзвэл 15-34 насны бага боловсролтой малчдын 93.3 хувийг эрэгтэй, 6.7 хувийг эмэгтэй малчид эзэлж байна. Харин 35-64 насны бага

боловсролтой малчдын 66.7-79.5 хүртэл хувийг эрэгтэй, 20.5-33.3 хүртэл хувийг эмэгтэй малчид, 65-аас дээш насны бага боловсролтой малчдын 46.9 хувийг эрэгтэй, 53.1 хувийг эмэгтэй малчид тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 19.


БАГА БОЛОВСРОЛТОЙ МАЛЧИД, хүйсээр, 2024 онд

Насны бүлгээр	Бүгд	Эрэгтэй		Эзлэх хувь	Эмэгтэй	
		эрэгтэй	эмэгтэй		эрэгтэй	эмэгтэй
Бүгд	261	184	77	100.0	70.5	29.5
15-24	15	14	1	100.0	93.3	6.7
25-34	30	28	2	100.0	93.3	6.7
35-44	81	54	27	100.0	66.7	33.3
45-54	44	35	9	100.0	79.5	20.5
55-64	42	30	12	100.0	71.4	28.6
>=65	49	23	26	100.0	46.9	53.1

Бүрэн дунд боловсролтой малчид нь 2675 буюу нийт малчдын 52.8 хувийг эзэлж байна. Дүүргээр нь авч үзвэл Багануур, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргүүд, Нийслэлийн дунджаас өндөр буюу тухайн дүүргийн нийт малчдын 53.6-58.6 хүртэл хувийг эзэлж байна.

ЗУРАГ 13.


ДҮҮРГИЙН МАЛЧДЫН ТООНД БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛТОЙ МАЛЧДЫН ЭЗЛЭХ ХУВЬ, дүүргээр, 2024 онд



Суурь болон техникийн болон мэргэжлийн, тусгай дунд боловсролтой малчид нийт малчдын 27.2 хувийг эзэлж байна. Дүүргээр нь авч үзвэл Сонгинохайрхан, Хан-Уул дүүргүүдэд эзэлж байгаа малчдын дундаж Нийслэлийн дунджаас бага буюу 23.9-24.7 хувь байна.

ЗУРАГ 14.

СУУРЬ БОЛОН ТЕХНИКИЙН, ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ДУНД БОЛОВСРОЛТОЙ МАЛЧДЫН ЭЗЛЭХ ХУВЬ, дүүргээр, 2024 онд



Дээд боловсролтой малчдыг хүйсээр нь авч үзвэл 57.5 (386) хувь нь эрэгтэй, 42.5 (285) хувь нь эмэгтэй малчид байна. Өмнөх онтой харьцуулахад 19.2 (108) хувиар өссөн үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 20.

ДЭЭД БОЛОВСРОЛТОЙ МАЛЧИД, хүйсээр, 2024 онд

Насны бүлгээр	Бүгд	Малчдын тоо		Бүгд	Эзлэх хувь	
		эрэгтэй	эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	671	386	285	100.0	57.5	42.5
15-24	8	6	2	100.0	75.0	25.0
25-34	147	82	65	100.0	55.8	44.2
35-44	245	140	105	100.0	57.1	42.9
45-54	130	71	59	100.0	54.6	45.4
55-64	71	40	31	100.0	56.3	43.7
>=65	70	47	23	100.0	67.1	32.9

3.5 Малчдын гэрлэлтийн байдал

Нийт малчдын 4194 буюу 82.8 хувь нь 2024 оны байдлаар гэрлэснээс 82.5 хувь нь батлуулсан, 17.5 хувь нь гэрлэлтээ батлуулаагүй байна. Харин 11.5 хувь нь огт гэрлээгүй, 0.8 хувь нь цуцалсан, 4.0 хувь нь бэлэвсэн, 0.9 хувь нь гэрлэлтээ тусгаарласан байна.

ХҮСНЭГТ 21.

МАЛЧДЫН ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, насны бүлэг, гэрлэлтийн байдлаар, 2024 онд

Насны бүлгээр	Бүгд	Огт гэрлээгүй	Гэрлэсэн		Тусгаарласан	Цуцалсан	Бэлэвсэн
			Батлуулсан	Батлуулаагүй			
Бүгд	5 067	582	3 461	733	48	38	205
15-24	185	144	21	19	-	-	1
25-34	672	201	290	168	5	4	4
35-44	1 302	120	922	239	13	1	7
45-54	1 424	72	1 091	187	19	18	37
55-64	967	33	759	89	8	11	67
>=65	517	12	378	31	3	4	89
Дүнд эзлэх хувь							
Бүгд	100.0	11.5	68.3	14.5	0.9	0.7	4.0
15-24	100.0	77.8	11.4	10.3	0.0	0.0	0.5
25-34	100.0	29.9	43.2	25.0	0.7	0.6	0.6
35-44	100.0	9.2	70.8	18.4	1.0	0.1	0.5
45-54	100.0	5.1	76.6	13.1	1.3	1.3	2.6
55-64	100.0	3.4	78.5	9.2	0.8	1.1	6.9
>=65	100.0	2.3	73.1	6.0	0.6	0.8	17.2

15-24 насны малчдын 77.8 хувь нь огт гэрлээгүй бол 65 ба түүнээс дээш насны малчдын 17.2 хувь нь бэлэвсэн байна. 35-44 насны нийт малчдын 89.2 хувь нь гэрлэсэн, 1.0 хувь нь тусгаарласан, 0.1 хувь нь цуцалсан, 0.5 хувь нь бэлэвсэн, 9.2 хувь нь огт гэрлээгүй

байна. 25-54 насанд хамаарах малчдын тоо гэрлэсэн боловч батлуулаагүй малчдын 81 хувийг, гэрлэлтээ тусгаарласан малчдын 77.1 хувийг, гэрлэлтээ цуцалсан малчдын 60.5 хувийг, бэлэвсэн малчдын 23.4 хувийг тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 22. МАЛЧДЫН ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, хувиар, дүүргээр, 2024 онд

Дүүрэг	Бүгд	Огт гэрлээгүй	Гэрлэсэн		Тусгаарласан	Цуцалсан	Бэлэвсэн
			Батлуулсан	Батлуулаагүй			
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Багануур	19.0	15.5	19.0	19.8	27.1	26.3	22.9
Багахангай	2.4	2.2	2.7	1.1	2.1	2.6	3.4
Баянзүрх	23.2	29.2	22.1	21.3	16.7	18.4	34.6
Налайх	14.3	12.9	13.9	16.2	18.8	5.3	20.0
Сонгинохайрхан	33.8	31.1	34.8	35.9	27.1	39.5	18.0
Хан-Уул	7.2	9.1	7.5	5.7	8.3	7.9	1.0

3.6 Малчдын гар утас болон интернэтийн хэрэглээ

2023 онд 4431 малчин гар утастай, 2630 малчин интернэт хэрэглэдэг байсан бол 2024 оны байдлаар нийт малчдын 99.1 хувь нь буюу 5019 малчин гар утас хэрэглэж байгаа нь өмнөх оноос 13.3 (588) хувиар өссөн байна.

Харин нийт малчдын 63.5 хувь нь буюу 3217 малчин интернэт хэрэглэж байгаа нь өмнөх оноос 22.3 (587) хувиар өссөн байгаа нь малчдын гар утас болон интернэтийн хэрэглээ жил бүр нэмэгдэж байгааг харуулж байна.


ХҮСНЭГТ 23. МАЛЧДЫН ГАР УТАС БОЛОН ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭЭ, насны бүлгээр

Насны бүлгээр	Гар утас		Өсөлтийн хувь	Интернет		Өсөлтийн хувь
	2023	2024		2023	2024	
Бүгд	4 431	5 019	13.3	2 630	3 217	22.3
15-24	159	184	15.7	123	143	16.3
25-34	583	665	14.1	414	494	19.3
35-44	1 201	1 294	7.7	824	930	12.9
45-54	1 279	1 411	10.3	745	940	26.2
55-64	840	956	13.8	402	503	25.1
>=65	369	509	37.9	122	207	69.7

Гар утастай малчдыг насны бүлгээр авч үзвэл, 15-24 насны малчдын 99.5 (184) хувь нь, 25-34 насны малчдын 99.0 (665) хувь нь, 35-44 насны малчдын 99.4 (1294) хувь нь, 45-54 насны

малчдын 99.1 (1411) хувь нь, 55-64 насны малчдын 98.9 (956) хувь нь, 65-аас дээш насны малчдын 98.5 (509) хувь нь гар утастай байна.

ЗУРАГ 15. МАЛЧДЫН ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, насны бүлгээр, дүнд эзлэх хувиар, 2024 онд




Гар утастай малчдын 3.7 хувь нь 15-24 насны, 67.1 хувь нь 25-54 насны, 29.2 хувь нь 55-аас дээш насны малчид байна.

ХҮСНЭГТ 24. МАЛЧДЫН ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, дүүргээр

Дүүрэг	Гар утас		Өөрчлөлт		Дүнд эзлэх хувь
	2023	2024	Дүн	Хувь	
Бүгд	4 431	5 019	588	13.3	100.0
Багануур	883	954	71	8.0	19.0
Багахангай	133	123	-10	-7.5	2.5
Баянзүрх	1 180	1 158	-22	-1.9	23.1
Налайх	597	720	123	20.6	14.3
Сонгинохайрхан	1 305	1 703	398	30.5	33.9
Хан-Уул	333	361	28	8.4	7.2

Гар утастай малчид өмнөх онтой харьцуулахад Багахангай болон Баянзүрх дүүрэгт 1.9-7.5 хувиар буурсан бол, Багануур, Налайх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүрэгт 8.0-30.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.


ЗУРАГ 16. НИЙТ МАЛЧДАД ГАР УТАСТАЙ МАЛЧДЫН ТОО, дүүргээр, 2024 онд



Нийслэлийн дунджаар 2024 оны байдлаар гар утастай малчдын эзлэх хувь 99.1 хувь байгаа бол Баянзүрх, Хан-Уул дүүргүүдийн хувьд гар утастай малчдын эзлэх хувь 98.3-98.9 хувь буюу нийслэлийн дунджаас доогуур байна. Харин Багануур, Налайх, Сонгинохайрхан дүүргүүдийн гар утастай малчдын эзлэх хувь 99.0-99.4 хувь буюу малчдын дунд гар утас хэрэглээ хамгийн өндөр буюу нийслэлийн дунджаас дээгүүр байна. Интернет хэрэглэдэг

малчдыг насны бүлгээр авч үзвэл, 15-24 насны малчдын 77.3 (143) хувь нь, 25-34 насны малчдын 73.5 (494) хувь нь, 35-44 насны малчдын 71.4 (930) хувь нь, 45-54 насны малчдын 66.0 (940) хувь нь, 55-64 насны малчдын 52.0 (503) хувь нь, 65-аас дээш насны малчдын 40.0 (207) хувь нь интернет ашиглаж байна. Үүнээс харахад 55-аас дээш настай малчдын хэрэглээ нийслэлийн дундаж хувиас доогуур байна.

ЗУРАГ 17. МАЛЧДЫН ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭЭ, насны бүлгээр, дүнд эзлэх хувиар, 2024 онд



Интернэт хэрэглэдэг малчдын 4.4 хувийг 15-24 насны залуу малчид, 15.4 хувийг 25-34 насны малчид, 28.9 хувийг 35-44 насны малчид, 29.2 хувийг 45-54 насны малчид, 15.6 хувийг 55-64 насны малчид, 6.4 хувийг 65-аас дээш насны малчид тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 25. ХҮСНЭГТ 25. МАЛЧДЫН ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭ, дүүргээр

Дүүрэг	Интернэт хэрэглэдэг малчид		Өөрчлөлт		Дүнд эзлэх хувь
	2023	2024	Дүн	Хувь	
Бүгд	2 630	3 217	587	22.3	100.0
Багануур	436	496	60	13.8	15.4
Багахангай	90	82	-8	-8.9	2.5
Баянзүрх	673	706	33	4.9	21.9
Налайх	296	367	71	24.0	11.4
Сонгинохайрхан	897	1 327	430	47.9	41.2
Хан-Уул	238	239	1	0.4	7.4

Интернэт хэрэглэдэг малчид өмнөх онтой харьцуулахад Багахангай дүүрэгт 8.9 хувиар буурсан бол, Сонгинохайрхан дүүрэгт 47.9 хувиар өссөн байна. Хан-Уул, Багануур,

Баянзүрх, Налайх дүүрэгт 0.4-24.0 хувь хүртэл өссөн үзүүлэлттэй байна. Гар утасны хэрэглээг дагаад интернэтийн хэрэглээ өмнөх онтой харьцуулахад 22.3 хувиар өссөн байна.

3.7 Зээлтэй малчид

Нийт малчдын 35.1 хувь нь буюу 1 776 малчин 2024 оны байдлаар зээлтэй ба өмнөх онтой харьцуулахад 212 малчнаар өссөн байна.

Зээлтэй малчдыг насны бүлгээр авч үзвэл 15-24 насны малчдын 20.5 хувь нь, 25-34 насны малчдын 31.3 хувь нь, 35-44 насны малчдын 41.9 хувь нь, 45-54 насны малчдын

37.9 хувь нь, 55-64 насны малчдын 31.9 хувь нь, 65-аас дээш насны малчдын 25.9 хувь нь зээлтэй байна.

ХҮСНЭГТ 26. ЗЭЭЛТЭЙ МАЛЧИД, насны бүлгээр

Насны бүлэг	Нийт малчид	Зээлтэй малчин		Зээлтэй малчдын нийт малчдад эзлэх хувь	Зээлтэй малчдын насны бүтэц, хувиар
		2023	2024		
Бүгд	5 067	1 564	1776	35.1	100
15-24	185	91	38	20.5	2.1
25-34	672	29	210	31.3	11.8
35-44	1 302	201	546	41.9	30.7
45-54	1 424	491	540	37.9	30.4
55-64	967	454	308	31.9	17.3
>=65	517	298	134	25.9	7.5

Зээлтэй малчдын 73.0 хувийг 25-54 насны малчид эзэлж байна. Насны бүлгээр нь нарийвчлан үзэхэд 15-24 насны малчид 2.1 хувийг, 25-34 насны малчид 11.8 хувийг, 35-44

насны малчид 30.7 хувийг, 45-54 насны малчид 30.4 хувийг, 55-64 насны малчид 17.3 хувийг, 65 болон түүнээс дээш настай малчид 7.5 хувийг тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 27.

ЗЭЭЛТЭЙ МАЛЧИД, дүүргээр

Дүүрэг	Зээлтэй малчид		Өөрчлөлт		Дүнд эзлэх хувь
	2023	2024	Дүн	Хувь	
Бүгд	1 564	1 776	212	13.6	100.0
Багануур	374	427	53	14.2	24.0
Багахангай	59	56	-3	-5.1	3.2
Баянзүрх	309	282	-27	-8.7	15.9
Налайх	215	230	15	7.0	13.0
Сонгинохайрхан	490	653	163	33.3	36.8
Хан-Уул	117	128	11	9.4	7.2

IV СҮРГИЙН БҮТЭЦ


Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувийн жинг 2024 оны байдлаар авч үзвэл, хонь 32.3 хувийг, ямаа 23.84 хувийг, үхэр 21.98 хувийг, адуу 21.85 хувийг, тэмээ 0.03 хувийг тус тус эзэлж байна.

Ямаан сүргийн эзлэх хувь 2024 онд өмнөх оноос 4.1 нэгж хувиар, хонин сүргийн эзлэх хувь 1.0 нэгж хувиар буурсан бол, үхэр сүргийн

эзлэх хувь 1.6 нэгж хувиар, адуун сүргийн эзлэх хувь 3.5 нэгж хувиар өсөж, тэмээн сүргийн эзлэх хувь өөрчлөлтгүй байна.

ЗУРАГ 18.

СҮРГИЙН БҮТЭЦ, малын төрлөөр, дүнд эзлэх хувиар




Малын тоо толгой сүүлийн жилүүдэд нэмэгдсэн ч таван төрлийн малын харьцаа сүргийн бүтцэд томоохон өөрчлөлт гарсан хэвээр байна.

Нийслэлийн хэмжээнд 1960-1990 он хүртэл оны мал тооллогын дүнгээс үзэхэд нийт мал сүрэгт бод мал дунджаар 60.2 хувь, бог мал дунджаар 39.8 хувийг эзэлдэг байсан бол 1991-2024 оны байдлаар бод мал дунджаар

29.5 хувь, бог мал дунджаар 70.5 хувийг эзэлж байна. Эндээс харахад 1990 оноос хойш жил ирэх тусам бод малын тоо багасаж, бог малын тоо нэмэгдсэн байна тэр дундаа хонины тоо толгойн сүрэгт эзлэх хувь нэмэгджээ.

ЗУРАГ 19.


НИЙТ МАЛД БОД МАЛ, БОГ МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ, оноор



Нийслэлийн хэмжээнд хонь, ямааны харьцаа 1965 онд 50:50 харьцаатай, 1970 онд 40:60 харьцаатай болж ямаан тоо толгой бог малд эзлэх хувьд нэмэгдсэн нь бэлчээр ашиглалтад зохистой харьцааг алдагдуулсан бол, 1975-2000 оны хооронд 75:25 буюу 3

хонинд 1 ямаа ногдож бэлчээрийн зохистой харьцааг хадгалж байсан. 1990 оноос хойш ноолуур үнэд орсонтой холбогдон, ямааны тоо толгой нэмэгдэж 2005 оноос хонины тоо толгойтой ижил түвшинд ирсэн байна.

ЗУРАГ 20. БОГ МАЛД ХОНЬ, ЯМААНЫ ЭЗЛЭХ ХУВЬ, ОНООР



